

"ОЮУН УХААНЫГ ШҮҮН ШИНЖЛЭХҮЙН" ТУХАЙ И.КАНТЫН СУРГААЛ

Г.Лодой. МУИС.НШУС.Философийн тэнхим. профессор.

Түлхүүр үгс: Танин мэдэхүйн оногдохуун, судлагдахуун, өөрөө буй юмс, априори ойлголт, ёс суртахууны эрхэмлэл захирамж,

Өрнө дахины иргэншлийг оюун ухаанаар соён гэгээрүүлэх их давалгаа эрч хүчээ авч байсан цаг үед Пруссийн вант улсын Кенигсберг буюу бидний нэрлэж заншснаар Калининград хотын ядуухан гар урлаачын гэр бүлд 1724 онд нэгэн хүү мэндэлсэн нь хойч үеийнхэндээ Германы сонгодог философийг үндэслэгч гэсэн алдраар дуурсагдах болсон И.Кант байжээ. Туурвил бүтээлийн их замаа байгалийн шинжлэлээс эхэлж, "Тэнгэрийн эрхэсийн жам ёсны түүх ба онол" /1755/ хэмээх зохиолдоо нарны систем сансрын мананцраас үүссэн тухай таамаглалыг дэвшүүлсэн нь одон орны ухаанд хөгжил хувьслын үзэл санааг нэвтрүүлсэн анхны алхам болж, хожим нь түүний таамаглалыг П.Лаплас математикийн онолоор баталжээ.

Шинжлэх ухааны танин мэдэхүйн үйл явцын тухай рационализм ба эмпиризмийн баримтлалын аль аль нь өрөөсгөл болохыг И.Кант ухаарч, энэхүү дутагдлыг арилгах арга замыг тодорхойлох эрэл хайгуулын явцдаа оюун ухааны бодомж, хэрэглэгдэх хүрээг оновчтой тогтоох нь шинжлэх ухааны мэдлэг үнэн байх гол нөхцөл мөн гэсэн ойлгоцонд хүрчээ. Энэхүү санаагаа үндэслэхийн тулд "Цэвэр оюун ухааныг шүүн шинжлэхүй" /1781/; "Практик оюун ухааныг шүүн шинжлэхүй" /1788/ "Үнэлэхүйн чадварыг шүүн шинжлэхүй" /1790/ хэмээх бүтээлүүд туурвиснаар И.Кант философийн сургаалынхаа тулгын гурван чулууг тавьсан байна.

И.Кантын философийн сургаалын тулгуур гол асуудал нь Хүн юуг танин мэдэж чадах вэ?, Хүн юу хийх ёстой вэ? Хүн юунд итгэх учиртай вэ? гэсэн гурамсан асуултанд хариу өгөх явдал байв. Эхний хоёр асуудлыг шинжлэн судлахад өмнө өгүүлсэн гурван бүтээлээ зориулсан бол "Гагцхүү оюун ухааны хүрээнд байх шашин" хэмээх зохиолоо гурав дахь асуудалд хариу өгөхөд И.Кант зориулж бичсэн ажээ.

1.Хүн юуг танин мэдэж чадах вэ?

Байгалийн шинжлэл, ялангуяа математикийн шинжлэх ухаан бидэнд үнэн зөв мэдлэг өгч байдаг нь огт эргэлзээгүй боловч ямар мэдлэгийг жинхэнэ шинжлэх ухааны мэдлэг гэж үзэх вэ гэдэг асуудлыг шинжлэхэд хэргийн учир орших ёстой гэж Кант үзээд, үүний тулд эн тэргүүнээ шинжлэх ухааны мэдлэгийн эх сурвалж, үндэслэлийг хянаж шалгах, тодорхойлох зорилтыг "Цэвэр оюун ухааныг шүүн шинжлэхүй" зохиолдоо шийдвэрлэх оролдлого хийсэн байдаг.

Танин мэдэхүйн оногдохуй ба судлагдахуун хоёр эрс ялгаатай бөгөөд оногдохуй нь биднээс хамаарахгүй орших байгалийн юмс, үзэгдэл, үйл явц буюу И.Кантын томъёоллоор "өөрөө буй юмс" байдаг бол тэдгээрийн тухай бидний мэдрэхүйн туршлагаар үүсдэг төсөөллүүд нь судлагдахуун болдог гэж И.Кант номлодог. Шинжлэх ухааны танин мэдэхүй нь объектив орших

юмс үзэгдлийн тухай бус, харин тэдгээрийг бид хэрхэн төсөөлж болох тухай мэдлэгийг бүтээдэг ажээ. Иймд шинжлэх ухааны мэдлэгийн бүтэц тогтолцоо, арга хэлбэрийг танин мэдэхүйн субьектээс өөрөөс нь тайлбарлах хэрэгтэй гэж И.Кант үзсэн буй.

Мэдрэхүйн туршлагаас үл хамаарах, априори шинжтэй боловч мэдрэхүйн төсөөллүүдийн хоорондын холбоо, харилцааг тогтоож, тэдгээрийг эмхлэн цэгцэлж нэгдмэл цогцолбор болгодог чадавхи оюун ухаанд өөрт нь байдаг бөгөөд түүнийг Кант орон зай, цаг хугацааны дараалалд сэтгэх чадавхи гэж нэрлэдэг. Юмсыг орон зай, цаг хугацааны дараалалд сэтгэх боломжит бүх загварын тухай мэдлэгийг математикийн шинжлэх ухаан өгөх ёстой бөгөөд энэ утгаараа математикийн шинжлэх ухаан нь байгалийн шинжлэлийн онолын гол тулгуур болох учиртай ажээ.

Орон зай, цаг хугацааны дараалалд сэтгэх априори загварыг мэдрэхүйн төсөөллүүдтэй холбосноор эмпирик мэдлэг үүсэх боломжтой бөгөөд эмпирик мэдлэгийг задлан шинжилж, түүний зайлшгүй, түгээмэл утга холбогдол, холбоо харилцаа зүй тогтлыг олж илрүүлэхэд логик сэтгэхүйн априори ойлголт, категориуд гол хэрэглүүр болдог байна. Ийм категориудыг И.Кант тоо, чанар, харилцан үйлчилгээ, магадлалт чанарыг илэрхийлэх ойлголтууд гэсэн дөрвөн бүлэгт хуваасан байдаг.

Тодорхой юмс, үзэгдлийн тухай мэдэхийн тулд эхлээд тэдний тухай ерөнхий ойлгоцтой байх шаардлагатай бөгөөд туршлагаас үл хамаарах шинжтэй, оюун ухааны өөрийнх нь чадавхийн үр дүн болох танин мэдэхүйн априори хэлбэрүүд энэхүү ерөнхий ойлгоцыг бүрдүүлдэг ажээ. Тэдгээрийг туршлагын материалыг боловсруулахад хэрэглэснээр шинжлэх ухааны мэдлэгийг бүтээдэг боловч шинлэх ухааны мэдлэг нь мэдрэхүйн туршлагын хүрээнээс хэзээ ч гарч чадахгүй учир бид байгалийг танин мэддэг бус, харин оюун ухааны бүдүүвчээр байгалийн хуулийг тайлбарладаг гэсэн үзэл баримтлалыг И.Кант танин мэдэхүйн сургаалдаа үндэслэхийг оролдсон юм.

Мэдрэхүйн туршлагын хязгаарын чандад орших юмсыг бүхэлд нь цогцолбор байдлаар тайлбарлах гэсэн тэмүүлэл нь оюун ухааныг зайлшгүй зөрчилд хүргэнэ гэж И.Кант үздэг. Ертөнцийг бүхэлд нь тайлбарлахыг оролдох аваас эсрэг, тэсрэг дүгнэлтүүд гарах нь зайлшгүй төдийгүй, тэдгээрийн аль аль нь утга төгөлдөр батлагдах боломжтой ажээ. Тухайлбал, ертөнц эхлэл, төгсгөлтэй, ертөнц хязгааргүй гэсэн эсрэг тэсрэг дүгнэлтүүдийн аль аль нь утга төгөлдөр батлагдах боломжтой хэмээн И.Кант нотлохыг оролдсон байдаг.

Шинжлэх ухааны онолын танин мэдэхүйн дээд шатанд зөрчил зайлшгүй үүсэх тухай И.Кантын дэвшүүлсэн асуудлыг Гегель диалектик логикийн сургаалдаа гол тулгуур болгосон ба орчин үеийн байгалийн шинжлэлийн арга зүйн онолын салбарт нягтлан судалж, зарим талаар үндэслэсэн баримт цөөнгүй буй. Танин мэдэхүйн үйл явцын зөрчилт шинжийн тухай үнэ цэнэтэй санааг И.Кант дэвшүүлсэн хэдий боловч түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлж чадсангүй, харин онолын сэтгэлгээг мэдрэхүйн туршлагын хүрээгээр хязгаарлаж, оюун ухааны эрхэм чухал үүрэг нь хүмүүний үйл ажиллагааг зохицуулахад оршино гэдгийг үндэслэхэд голлон анхаарсан байдаг.

2. Хүн юу хийх ёстой вэ?

Ертөнцийг танин мэдэхүйд оюун ухааны гүйцэтгэх үүрэг нь арга зүйн ерөнхий удирдамж өгөхөөс хэтэрдэггүй боловч хүн өөрийгөө хэн болохыг ухаарч, тэрхүү ухаарлынхаа үүднээс үйл ажиллагаа явуулах хэм хэмжээний хуулиудыг оюун ухаан тогтоон тодорхойлж, захирамжлах ёстой ажээ. И.Кантын философийн гол тулгуур асуудал нь хүний тухай асуудал болой гэж олон судлаач тэмдэглэсэн байдаг.

Ёс суртахууны дээд эрхэмлэлийг бодгалийн мэдрэхүйн таашаал, сэтгэлийн тэмүүллээс тайлбарлах нь учир дутагдалтай ажээ. Ёс суртахууны эрхэмлэл нь амин хувийн ашиг сонирхол, амьдрахуйн хэрэгцээ, нөхцөл байдлаас үл хамаарах, хүн бүхэн зайлшгүй дагаж мөрдөх ёстой оюун ухааны захирамж байх ёстой гэж И.Кант үздэг. "Хүмүүн төрөлхтөн хэн бээр өөрөө болон өрөөл бусад нь ч байсан үйл ажиллагааны хэрэглүүр бус, эрхэм зорилго болох ёстой" гэсэн томъёоллоор ёс суртахууны гол зарчмыг И.Кант тодорхойлсон байдаг. Ертөнцөд хүнээс илүү эрхэм зүйл үгүй гэсэн санаа энэхүү зарчмын гол агуулга нь юм.

Хүнийг эрхэмлэн дээдлэх зарчмыг ёс суртахууны удирдлага болгосноор хүн бүр эрх төгөлдөр чөлөөт байдалд үйл ажиллагаа явуулах боломжтой болох төдийгүй, амин хувийн явцуу ашиг сонирхол, хүсэл тэмүүллээ хазаарлан барьж буяны үйлийг бүтээх нөхцлийг бүрдүүлэх учиртай ажээ. Энэ утгаараа ёс суртахууны түгээмэл хуулийг буюу оюун ухааны захирамжийг ухамсарласан чөлөөт үйл ажиллагаа нь аз жаргалтай байхын үндэс болдог байна. Хувийн аз жаргалын төлөө үйлийг бүтээх бус, ёс суртахууны дээд эрхэмлэлийн удирдамжаар хийсэн үйл нь аз жаргалыг авч ирэх ёстой гэж И.Кант үздэг.

Оюун ухааны захирамжаар хүн үйл ажиллагаагаа явуулах нь эрхэм зорилго хэдий боловч хувь хүн түүнийг тэр болгон мөрдөж чаддаггүй учир нийгэмд зерчил, тэмцэл байнга үүсч байдгийг И.Кант үгүйсгээгүй юм. Ёс суртахууны хууль бодит байдалд бүрэн хэрэгжсэн эрх төгөлдөр нийгэм байж болохыг хүмүүст ухааруулахын тулд тэдэнд итгэл төрүүлэх нь чухал болохыг И.Кант номлосон байдаг.

3. Хүн юунд итгэх учиртай вэ?

Итгэлийг төрүүлэх туйлын эрхэмлэл байхгүй бол ёс суртахууны хуулийг дагаж мөрдөх баталгаа алдарна гэсэн санааг И.Кант ёс суртахууны тухай сургаалынхаа нэгэн чухал хэсэг болгож үндэслэхийг оролдсон юм. И.Кантын ойлгоцоор "бурхан" бол ертөнцийг бүтээгч ч бус, ёс суртахууны хэм хэмжээг айлдагч христос шашны бурхан ч бус ажээ. "Бид аливаа үйлийг бурханы айлдвар учраас хийх ёстой бус, харин түүнийг оюун ухааны захирамжаар хийх ёстой учир бурханы айлдвар гэж үзэх ёстой" гэж И.Кант тэмдэглэсэн байдаг.

Ёс суртахуун шашнаас хараат байх бус, харин шашин ёс суртахуунаас хамааралтай байх учиртай ажээ. Бурхан тэнгэрийн айлдварын тухай аливаа номлол бол хоосон ойлголт бөгөөд шашны сүсэг бишрэлээр үүсдэг итгэл нь "хүний сэтгэлийг хордуулагч хар тамхи" лугаа юм гэж И.Кант үзээд, бурхныг зөвхөн ёс суртахууны билэгдэл төдий хэмжээнд ойлговол

"ашиг тустай үзэл санаа" байх болно гэсэн санааг үндэслэсэн буй. И.Кант Азид төрсөн бол буддист байх байсан биз гэж нэгэн судлаач тэмдэглэсэн байдаг.

"Агуулгын хувьд шашин ёс суртахуунаас огт ялгаагүй" бөгөөд бурхан бол "оюун ухаан өөртөө зориулж бүтээсэн ойлголт" юм гэж И.Кант үздэг. "Ёс суртахууныг шашнаас илүү шүтэн бишрэх хэрэгтэй" учир "ёс суртахуунд аливаа шашны хэрэгцээ байхгүй" ажээ. Библи судар бол ёс суртахууныг бурхны хэлээр илэрхийлсэн өгүүлэмжийн хураамж болох тул түүнийг хэрхэн тайлбарлах нь оюун ухаанаас хамаарах учиртай хэмээн И.Кант үзэж байв. "Гагцхүү оюун ухааны хүрээнд байх шашин" хэмээх И.Кантын зохиолын нэрийн учир ийм ажгуу.

Ёс суртахууны дээд эрхэмлэлд итгэх итгэл алдарсан нийгэмд бурхан гэж байхгүй болох учир "хүн өөрөө үйл ажиллагааны хэрэглүүр бус, харин дээд эрхэмлэл байх ёстой" гэсэн оюун ухааны захирамжаар нийгмийн харилцааг захируулахад ёс суртахууны үүргээ ухамсарлах хэрэглүүр болгон "хүмүүнийг эрхэмлэн шүтэх шашныг" бий болгох нь чухал болохыг И.Кант номлож байжээ. Эл санаа хожим нь Л.Фейербахын хүн судлалын материализмын үзэл санааны нэгэн тулгуур баримтлал болсон юм.

"Оюун ухааныг шүүн шинжлэх" зорилтыг дэвшүүлж, танин мэдэхүй, үйл ажиллагаа, үнэлэхүйн зарчмуудыг оюун ухааны чадавхийн боломжийн хүрээнд тодорхойлох оролдлого хийхдээ И.Кантын дэвшүүлсэн олон чухал асуудлууд эдүгээ үед ч судлаачдын анхаарлыг татсаар байгаа билээ. Асуудлыг оновчтой томъёолох нь үндэслэл муутай шийдвэрээс илүү үнэ цэнэтэй байдаг учиртай. Дэвшүүлсэн асуудалдаа бүх талаар үндэслэсэн төгс хариултыг И.Кант өгч чадаагүй болох нь ойлгомжтой бөгөөд субъектив идеализм, материализм, агностицизм, шашин, атеизмын үзэл баримтлалын аль альных нь талд үйлчлэх боломжтой санаа дүгнэлтүүд түүний философийн судалгаанд цөөнгүй байдгийг анхаарууштай билээ.